



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 11460

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэзуу хийдийн аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулах, үзмэрийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: -Т.Эрдэнэсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: А.Баяндуурэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Авирамэд -Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн(зөвшилцөнөөр)
Д.Уранцэцэг -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төсөв, санхүүгийн ажилтан

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100792

D:My Doc. Zahiramj. Zasag darga